



## **АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО ХХК-ИЙН 2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

Монгол улс, Улаанбаатар хот  
Чингэлтэй дүүрэг, Сүхбаатарын талбай - 3  
Утас: 70113672,  
Факс: 976-11-70110104  
E-mail: info@mscc.mn

## 1. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Сангийн Сайдын 2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 1 дүгээр тушаалаар төрийн төлөөлөл хэрэгжүүлж байсан ТУЗ-ийн 2 гишүүнийг чөлөөлж, 1 гишүүнийг шинээр томилсноор 6 гишүүнтэй ажилласан бөгөөд хараат бус 3 гишүүнийг сонгон шалгаруулах ажлыг 2 болон 6-р саруудад зохион байгуулан шийдвэр гаргуулахаар хүлээгдэж байна.

Тайлант хугацаанд ТУЗ хоёр удаа хуралдаж нийт 10 асуудлыг хэлэлцэн 4 тогтоол, 6 тэмдэглэл гаргажээ.

## 2. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компани 2019 оны эхний хагас жилд МХБ-ээр арилжигдсан үнэт цаасны арилжааны тооцоог харилцагч, үнэт цаасны компани, төлбөр гүйцэтгэх банк тус бүрээр гүйцэтгэж, анхдагч зах зээлийн арилжааны төлбөрийг харилцагч тус бүрээр шууд, хоёрдогч зах зээлийн арилжааны төлбөрийг цэвэршүүлсэн дүнгээр Төлбөр гүйцэтгэгч банк тус бүрээр хийж гүйцэтгэж ирлээ. Мөн Засгийн газрын үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийн гүйлгээг харилцагч нэг бүрийн төлбөр тооцооны дансанд байршуулах, ҮЦК-ийн зөвшөөрлөөр арилжааны банк дахь харилцагчийн банканд шилжүүлэх гүйлгээг хийж байна.

Эрсдэлийн удирдлагын нэгж нь төлбөр тооцооны DvP зарчим, дараа төлбөрт тооцоог зах зээлд нэвтрүүлэхтэй холбоотойгоор EBRD-ийн зөвлөх багаас ирүүлсэн санал зөвлөмж, журмын төсөлтэй танилцах, байгууллага доторх DvP-ийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн төлөвлөгөө гаргах, үүсч болзошгүй эрсдэлийг тооцох, урьдчилан сэргийлэх аргачлалтай холбоотой судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

### 2.1 Төлбөр тооцооны үйл ажиллагаа

Компани Монголын хөрөнгийн бирж дээр арилжигдсан үнэт цаасны арилжааны төлбөр тооцоо, засгийн газрын үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийн гүйлгээг хийж гүйцэтгэж байна.

Өнөөдрийн байдлаар үнэт цаасны зах зээл дээр анхдагч ба хоёрдогч зах зээлийн арилжааны төлбөр тооцооны горим үйлчилж байна.

#### 2.1.1 Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны төлбөр тооцоо

МХБ дээр хийгдэж байгаа үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны төлбөр тооцоо Т+0 өдрөө дараах зарчмаар хийгдэж байна.

# “АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО ҮЦК” ХХК



Зураг: Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны төлбөр тооцоо

2019 оны эхний хагас жилийн байдлаар үнэт цаасны анхдагч зах зээлд засгийн газрын бонд, компанийн бондын арилжаа хийгдээгүй бөгөөд 4 компанийн IPO хийгдэж 42,457,356,260.00 төгрөгийн төлбөр тооцоог хийж гүйцэтгэлээ. Хувьцааны анхдагч зах зээлийн арилжаанд нийт 47 ҮЦК оролцож нийт 1,105,584,457.05 төгрөгийн шимтгэл тооцогдсон байна.

Хүснэгт: Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа

(төгрөг)

Он	Засгийн газрын бонд	Компанийн бонд	Хувьцаа	Нийт
2019-II	-	-	42,457,356,260.00	42,457,356,260.00

## 2.1.2 Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааны төлбөр тооцоо

МХБ дээр хийгдэж байгаа үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааны төлбөр тооцоо нь Төлбөр гүйцэтгэгч банканд дээр T+1 хугацаанд дараах зарчмаар хийгдэж байна.

Зураг: Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааны төлбөр тооцоо



## “АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО ҮЦК” ХХК

2019 оны эхний хагас жилийн байдлаар үнэт цаасны хоёрдогч зах зээлд МХБ-ээр нийт 124 удаагийн арилжаа явагдсан бөгөөд үүнээс 124 удаагийн арилжаанд 39,861,737,670.27 төгрөгийн хувьцааны, 21 удаагийн арилжаанд 8,294,281,788.26 төгрөгийн ЗГҮЦ-ны, нийт 48,156,019,458.53 төгрөгийн хоёрдогч зах зээлийн арилжаа явагдсан бөгөөд хоёрдогч зах зээлийн арилжааны төлбөр тооцоог Т+1 хугацаанд цэвэршүүлэн 9,824,224,105.43 төгрөгийн төлбөр гүйцэтгэсэн байна. Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаанд 48 ҮЦК оролцож нийт 465,042,057.74 төгрөгийн шимтгэл тооцогдсон байна.

### Хүснэгт: Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

( төгрөг)

Он	Засгийн газрын бонд	Компанийн бонд	Хувьцаа	Нийт	Төлбөрийн цэвэршүүлсэн дүн
<b>2019-II</b>	8,294,281,788.26	0.00	39,861,737,670.27	48,156,019,458.53	9,824,224,105.43

### Үнэт цаасны арилжааны мэдээ /ҮЦК-иар/

д/д	ҮЦК Код	ҮЦК-ны нэр	Анхдагч зах зээлийн арилжаа	Хоёрдогч зах зээлийн арилжаа	Нийт шимтгэл
1	2	"Масдак ҮЦК" ХХК	41,578,609.00	555,028,873.08	4,383,117.85
2	4	"Санар ҮЦК" ХХК	10,792,500.00	42,440,162.30	400,134.08
3	5	"Зэргэд ҮЦК" ХХК	157,593,867.00	188,020,824.12	2,936,966.87
4	6	"Мэргэнсанаа ҮЦК" ХХК	29,800,178.00	38,893,002.47	853,950.09
5	7	"Би ди сек ҮЦК" ХК	1,352,795,751.00	4,051,393,218.27	42,612,253.61
6	9	"Өндөрхаан Инвест ҮЦК" ХХК	47,261,409.00	89,716,079.15	1,330,811.70
7	10	"Алтан хоромсог ҮЦК" ХХК	6,535,600.00	63,718,955.00	564,000.91
8	13	Булган брокер	44,213,086.00	16,205,047.80	704,123.04
9	15	"Дархан брокер ҮЦК" ХХК	55,696,178.00	310,247,079.49	2,872,458.12
10	18	"Монсек ҮЦК" ХХК	48,234,452.00	325,894,863.81	2,899,861.58
11	19	"Тулгат чандмань баян ҮЦК" ХХК	72,073,560.00	148,744,927.53	1,744,423.31
12	21	"Бумбат-Алтай ҮЦК" ХХК	427,078,827.00	6,502,371,192.36	45,933,724.94
13	22	Азиа пасифик секьюритис	2,531,830.00	3,284,265.65	69,933.63
14	25	"Таванбогд ҮЦК" ХХК	34,054,681.00	222,391,248.85	1,862,157.45
15	27	"Арвай бэст ҮЦК" ХХК	1,910,800.00	41,546,078.06	368,499.33
16	29	Дэлгэрхангай секьюритиз	15,066,740.00	109,407,239.31	1,166,310.33
17	31	"Гендекс ҮЦК" ХХК	12,647,461.00	189,846,487.76	1,406,290.09
18	32	Ард секьюритиз ҮЦК ХХК	2,140,836,053.00	4,338,369,381.63	51,658,826.20
19	45	Батс	143,838,705.00	293,720,176.05	4,452,477.52
20	47	"Нэйшнл сэкьюритис ҮЦК" ХХК	5,051,658.00	26,431,464.90	249,764.11
21	49	"Блүмсебюри секьюритис ҮЦК"	55,625,667.00	209,610,008.93	1,964,885.68
22	50	Ди си эф	-	3,077,823.55	20,929.19
23	51	"Эм ай си си ҮЦК" ХХК	1,594,143.00	74,607,688.50	547,185.92
24	52	"Тэнгэр капитал ҮЦК" ХХК	44,885,952.00	8,399,455,174.88	1,189,956.38

## “АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО ҮЦК” ХХК

25	54	Эф си икс	8,829,160.00	-	264,701.20
26	57	"Ард капитал групп ҮЦК" ХХК	7,089,004,423.00	1,887,422,442.28	241,864,058.60
27	58	Эм ай би жи	10,204,980.00	165,610,640.70	1,330,113.38
28	59	"Гаули ҮЦК" ХХК	269,924,816.00	1,395,712,147.31	12,894,632.27
29	61	"Лайф тайм инвестмент ҮЦК" ХХК	25,119,257.00	2,363,335,851.91	15,944,589.38
30	62	Евразиа капитал холдинг	3,785,188.00	20,005,625.20	184,010.14
31	64	"Гүүдсек ҮЦК" ХХК	204,037,425.00	287,833,127.94	4,442,547.18
32	71	"Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК	19,946,672,021.00	2,129,670,741.76	155,578,162.36
33	72	Эс Жи Капитал	200,000.00	3,970.00	3,027.00
34	75	Новел инвестмент	203,523,319.00	1,724,666,907.82	7,499,841.43
35	78	"Апекс капитал ҮЦК" ХХК	106,523,413.00	3,233,446,776.22	22,550,407.03
36	100	"Стандарт Инвестмент ҮЦК" ХХК	824,598,718.00	1,996,093,276.55	23,010,163.42
37	101	Гранддевелопмент	9,016,989.00	329,893,524.15	2,313,558.70
38	106	Гацуурт трейд	1,889,487.00	14,490,211.40	111,381.95
39	110	"Зэт Жи Би ҮЦК" ХХК	23,008,292.00	43,132,419.38	693,356.70
40	114	"МИРЭ ЭССЕТ СЕКЬЮРИТИС МОНГОЛ ҮЦК" ХХК	244,469,913.00	10,579,257,379.85	26,865,319.15
41	120	"Голомт капитал ҮЦК" ХХК	28,978,662,940.00	41,622,770,096.37	661,206,631.69
42	121	Сикап	37,538,102.00	21,812,486.00	657,707.95
43	124	Блюскай секьюритиз	11,381,782.00	19,119,758.80	357,650.00
44	125	ХҮННУ ЭМПАЙР	79,258,602.00	98,206,657.87	1,570,341.28
45	127	СИЛВЕР ЛАЙТ СЕКЬЮРИТИЗ ҮЦК ХХК	133,083.00	21,990,097.00	151,007.05
46	128	"Централ Секюритийз" ХХК	420,000.00	184,223,070.01	1,241,001.06
47	130	"Инвескор Капитал ҮЦК" ХХК	17,087,865,300.00	250,560,572.00	172,582,464.85
48	501	ГОЛОМТ КАСТОДИАН	4,996,947,603.00	1,186,832,496.87	41,872,718.09
49	503	ХААН КАСТОДИАН	-	491,527,377.00	3,244,081.00
			84,914,712,520.00	96,312,038,917.83	1,570,626,514.79

### 2.2 Төлбөрийн үйл ажиллагаа

Төлбөрийн үйл ажиллагааны хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Монгол банкны төлбөрийн системийн оролцогчийн хувьд Монгол банкны төлбөрийн системийн шинэчлэлийн хүрээнд зохион байгуулагдсан АСН систем нэвтрүүлэх ажлын хэсэгт орж ажиллаж байна.
2. Төлбөрийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулахтай холбоотой дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:
  - 2018.12.31-ны байдлаар дансандаа үлдэгдэлтэй 74 ҮЦК-ны 3 867 харилцагчийн төлбөр тооцооны дансны 952,571,892.10 төгрөгийн үлдэгдэлийг тулган баталгаажуулахаар ҮЦК-иудад албан тоот хүргүүлж 36 ҮЦК-иас 3,750 харилцагчийн 931,223,717.20 төгрөгийн үлдэгдлийн баталгаажуулалтыг хүлээн авсан.
  - СЗХ-ноос номинал дансны үйлчилгээ үзүүлэх эрх авсан Ард секьюритис компанитай төлбөр тооцооны номинал данс ашиглах тухай гэрээ байгуулсан.
  - Ард секьюритис ҮЦК-тай байгуулсан 80 харилцагчийн номиналь дансны гэрээг системд бүртгэсэн.

## “АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО ҮЦК” ХХК

- Үнэт цаасны арилжааны төлбөр тооцооны тайланг ТГБ, ҮЦК-иар гаргуулдаг болгосон. Энэ нь e-clearing, MIT –аар гарч байгаа тооцоолуудыг тулгаж хянах, судалгаа гаргах боломжтой болсон.
  - Монгол банкны үлдэгдлийн тайланг e-clearing-ийн “Харилцах банкуудын дансны үлдэгдэл”-тэй тулж гардаг байлгах аар зохицуулан эхний ээлжинд Монгол банкны хаалтын гүйлгээний жагсаалт e-clearing-д харагддаг болсон.
  - Мөнгөн хөрөнгийн гүйлгээний програм дээр Монголбанкны банк хоорондын шимтгэлийн тайланг шинэчлэв.
  - “Гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын арилжааны үнийн дүнд эзлэх хувь” судалгааг анхдагч, хоёрдогч зах зээлээр салгаж гаргах боломжтой болсоноор арилжааны шимтгэлийн судалгааг тооцох тооцоолол хялбар болсон.
3. Үнэт цаасны арилжааны төлбөрийг дараах байдлаар гүйцэтгэж байна.
    - Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны төлбөрийг хийхдээ төлбөр гүйцэтгэгчийн үүргийг гүйцэтгэж байна.
    - Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааны төлбөрийг Төлбөр гүйцэтгэгч банкны түвшинд цэвэршүүлсэн дүнгээр гүйцэтгэж байна.
  4. Засгийн газрын үнэт цаасны үндсэн ба хүүгийн төлбөрийг харилцагчдад тараах үйл ажиллагааг 2016 оны 09 дүгээр сарын 19-ны өдрөөс эхлэн гүйцэтгэсэн бөгөөд 2019 оны эхний хагас жилд 158.7 тэрбум төгрөгийн орлогын, 158.9 тэрбумын зарлагын гүйлгээ гүйцэтгэв.

Он	Эхний үлдэгдэл	Орлого	Орлогын бүтэц			Зарлага	Эцсийн үлдэгдэл
			ЗГҮЦ-ны үндсэн болон хүүгийн төлбөр	Хоёрдогч зах зээлийн арилжааны төлбөр /цэвэршүүлсэн дүнгээр/	Анхдагч зах зээлийн арилжааны төлбөр		
2016	-	859,278.9	523,101.3	8,958.0	327,219.6	859,188.3	90.6
2017	90.6	4,906,581.9	4,067,453.9	27,737.5	811,390.5	4,904,500.8	2,171.7
2018	2,171.7	2,000,953.9	1,853,634.8	33,395.7	113,923.4	2,002,173.0	952.6
2019-II	952.6	158,745.9	91,567.0	9,824.2	57,354.7	158,933.1	765.4
Нийт		7,925,560.6	6,535,757.0	79,915.4	1,309,888.2	7,924,795.2	

### 2.3 Эрсдэлийн удирдлага

Төлбөр тооцооны эрсдлийн удирдлагын хүрээнд дараахь ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төлбөр тооцооны системд дараа төлбөрт тооцоог нэвтрүүлэхтэй холбоотой DvP-ийн ажлын хэсэгт орж ажиллалаа.
  - EBRD-ийн зөвлөх багаас ирүүлсэн эрсдлийн удирдлагын зөвлөмж, аргачилалыг орчуулах, танилцах ажлуудыг хийж гүйцэтгэсэн
  - МХБ-ээр арилжигдаж байгаа үнэт цаасны ханшийн хэлбэлзлийг тооцож, үүсч болзошгүй эрсдэлийг үнэлж, судалгаа хийх аргыг хэвшүүлэх зорилгоор ХК-иудын талаар мэдээллийн сан үүсгэх, 1-р ангиллийн компаниудын зах зээлийн болон дансны үнэлгээ, санхүүгийн үзүүлэлтийн нэгтгэл, санхүүгийн харьцаануудыг хийх, VAR аргаар АПУ, Говь, Таван толгой гэсэн 3 компани

дээр үнэт цаасны биржийн журманд тооцоолсон томъёогоор тооцож хэр үнэн бодитой тооцоолж байгааг туршиж DvP-ийн ажлын хэсэгт танилцуулах зэрэг ажлуудыг хийсэн.

- МХБ-ийн гишүүн ҮЦК-иудын төлбөрийн чадварыг шинжлэх зорилгоор тайлангаа ирүүлсэн 45 ҮЦК-иас дүрмийн сангаа нэмэгдүүлсэн 9 компани дээр төлбөрийн чадвар буюу харьцаануудын шинжилгээ хийсэн.
- Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын зарчмуудын (PFMI) хэрэгжилт үнэт цаасны төлбөр тооцооны системийн хувьд хэрхэн хангагдаж байгааг тодорхойлж, үнэлгээг хийх зорилгоор 2017 хийгдсэн үнэлгээтэй танилцаж, судлах ажлыг хийсэн.
- ҮЦК-иудын төлбөрийн чадварын эрсдэлийг тодорхойлох программ хангамжийн жишиг үнийг тодорхойлох зорилгоор судалгаа хийсэн бөгөөд Прософт ХХК, Конпиг ХХК -тай холбогдоход 3 сарын дотор 25 сая төгрөгөөр гүйцэтгэх боломжтой тухайгаа мэдэгдсэн.

### 3. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

#### Компанид ашиглагдаж буй систем

Одоогоор манай компани нь анхдагч зах зээлийн хувьд Монголын хөрөнгийн биржээр арилжаалагдаж тооцоо болон төлбөрийн үйл ажиллагааг, харин хоёрдогч зах зээлийн хувьд зөвхөн мөнгөн төлбөрийг цэвэршүүлсэн дүнгээр Төлбөр гүйцэтгэх банкуудын хооронд хийж байгаа бөгөөд эдгээр үйл ажиллагааг дотооддоо хөгжүүлсэн E-Clearing House болон Millennium CSD системүүдийг үндсэн үйл ажиллагаандаа ашиглаж байна. Эдгээр системүүд нь өөр өөрийн гэсэн онцлог давуу талтай хэдий ч мөнгөн төлбөрийг 100% урьдчилан байршуулдаг, мөнгө үнэт цаасны хооронд төлбөрийн эрсдлийг хянах боломжгүй зэрэг нь цаашид төлбөр тооцооны шинэ систем нэвтрүүлэх үндсэн шаардлагыг бий болгож байна.

Байгууллагын хувьд одоогийн үйл ажиллагаандаа ашиглагдаж буй E-Clearing house системийн хувьд дотоод нөөц бололцоогоо ашиглан хөгжүүлэх боломтой учир тухай бүр хэрэглэгчийн шаардлагаар хөгжүүлэлтийг хийж байна. 2019 оны эхний хагас жилд дараах томоохон засвар өөрчлөлтийг хийсэн. Үүнд:

#### *3.1.1 E-Clearing House системтэй холбоотой хийгдсэн ажил*

Системийн хувьд компанийн үндсэн үйл ажиллагааг хөнгөвчлөх, төлбөр тооцоог түргэн шуурхай гүйцэтгэх үүднээс зарим шаардлагатай өөрчлөлтүүдийг тухай бүр хийж гүйцэтгэж байгаа бөгөөд 2019 оны эхний хагас жилд хийсэн томоохон нэмэлт өөрчлөлтүүдийг дурьдвал:

#### Системийн засвар өөрчлөлт

- Хоёрдогч зах зээлийн мөнгөн төлбөр тооцооны тайланг нэмж хөгжүүлсэн
- Монгол банкны төлбөрийн үйл ажиллагаатай холбоотой нэмэлт хөгжүүлэлтүүдийг хийсэн. /буцаалтын гүйлгээ, лавлагаа г.м/

- Мэргэжлийн байгууллагуудын шимтгэлийн тайлан судалгаа гаргах боломжтой болсон
- Төлбөрийн үйл ажиллагааг сайжруулах үүднээс харилцагчийн 1 банкны данс бүртгэгддэг байсан бол арилжааны 2 банкны данс болон гадаад төлбөр тооцооны 1 дансыг бүртгэх боломжтой болсон.

### ҮЦТХТ ХХК-тай мэдээлэл солилцох гэрээний хүрээнд

ҮЦТХТ ХХК-тай мэдээлэл солилцох гэрээний дагуу өдөр бүр тухайн өдөр нээгдсэн дансны мэдээллийг хоёр байгууллагын хооронд системийн түвшинд дамжуулан авч өөрийн төлбөр тооцооны дансны мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн Засгийн газрын бондын эргэн төлөлтийг төлбөр тооцооны дансанд байршуулах зорилгоор бонд эзэмшигчдийн мэдээллийг ҮЦТХТ ХХК-иас тусгай программын тусламжтайгаар хүлээн авч төлбөр тооцоог хийж гүйцэтгэж байна.

#### **3.1.2 Миллениум АйТи систем (CSD)**

Энэхүү системээс арилжааны мэдээлэл болон төлбөр тооцооны мэдээллийг авах, ҮЦК болон Төлбөр гүйцэтгэх банкуудруу төлбөр тооцооны мэдээ хүргүүлэх байдлаар ашиглаж байна.

MIT CSD системээс Төлбөр гүйцэтгэх 6 банк болон үнэт цаасны компаниуд төлбөр тооцооны файлыг өдөр бүр арилжааны дараа хүлээн авч ажилладаг. Энэ нь Т+1 өдрийн төлбөрийн мэдээлэл бөгөөд аливаа алдаа доголдол гарсан даруйд Миллениум АйТи системийн холбогдох багийнхантай холбогдон тодруулга авч мэргэжлийн байгууллагуудад хүргүүлдэг. 2019 оны эхний улиралд Кастодионы дансаар арилжаанд орсон тохиолдолд Төлбөр гүйцэтгэх банкны төлбөрийн мэдээлэл зөрүүтэй тооцогдсон асуудал үүссэн бөгөөд аливаа алдаа доголдлыг тухай бүр мэдээлэн засварлуулах тал дээр анхаарч ажиллаж байна.

#### **3.1.3 Санхүүгийн програм (SolarSys)**

2018 онд нэвтрүүлсэн SolarSys системд дараах нэмэлт өөрчлөлтүүдийг оруулсан. Үүнд:

- Бараа материалын код хэвлэх;
- Харилцахын орлого зарлага хийхэд гүйлгээний утгыг үгээр хайх;
- Үндсэн хөрөнгийн элэгдлийн эхний үлдэгдэл оруулах.

Компанийн НБББББ-т тусгагдсан зарим гүйлгээнүүдийг автоматжуулах, бодолтыг өөрчлөх зэрэг нэмэлт хөгжүүлэлтийг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

#### **3.1.4 Банк хоорондын систем (RTGS, ISO8583, ACH+)**

Компани банк хоорондын системд 2016.04.18-ны өдрөөс эхлэн 07 бик кодоор шууд холбогдон гүйлгээ дамжуулж байгаа бөгөөд их дүнтэй гүйлгээг RTGS систем, бага дүнтэй гүйлгээг ISO8583 системээр дамжуулан өдөр тутмын арилжааны төлбөр тооцоог найдвартай тасралтгүй гүйцэтгэж байна.



Монголбанк, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийн хүрээнд их дүнтэй гүйлгээний RTGS системийн II үеийн хувилбарт 2018 оны нэгдүгээр сарын 26-ны өдөр бүрэн шилжсэн. Дараагийн шатны шинэчлэл болох бага дүнтэй гүйлгээний АСН+ төсөл нь системийн томоохон өөрчлөлт орох систем учир гэрээт компаниар хөгжүүлэхээр байгууллагынхаа төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.

АСН+ систем нь банк оролцогчийн дотоод системээс 24/7 хугацаанд тасралтгүй ажиллах шаардлагатай бөгөөд мөн оролцогчдын гүйлгээг хянах, баталгаажуулах, гүйлгээ хийх зэрэг веб интерфэйс бүхий системийг агуулдаг. Энэхүү системд шилжихэд дотоод сургалт болон заавар, холбогдох дотоод хөгжүүлэлтийг хийж хамтран турших, Монгол банк болон бусад банкуудтай туршилтын төлөвлөгөөний дагуу туршилт хийх зэрэг ажлууд дээр төвлөрч ажилласан болно.

### **3.1.5 ҮЦК-уудад мэдээлэл хүргэх систем (API)**

Анхдагч зах зээлийн арилжааны болон төлбөр тооцооны мэдээллийг түргэн шуурхай, найдвартай гүйцэтгэх, мөн эцсийн хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэдэг ҮЦК-уудад шаардлагатай мэдээллийг цаг алдалгүй хүргэх үүднээс ЭйПиАй (API) нэвтрүүлсэн бөгөөд энэ нь:

1. Харилцагчийн үлдэгдэл харах;
2. Харилцагчийн хуулга харах;
3. Арилжааны мэдээ гаргах; /тухай БДК-иар/
4. Данс болон дансны төлөв шалгах зэрэг боломжүүдийг бодит цагаар дамжуулах;
5. Харилцагчийн шимтгэл засварлах боломжуудтай юм.

Үнэт цаасны компаниудад API эрх олгохдоо “Мэдээлэл дамжуулах гэрээ” байгуулж байгаа бөгөөд 2019 оны эхний хагас жилийн байдлаар нийт 18 ҮЦК –тай мэдээлэл дамжуулах гэрээ байгуулж эрх олгосон.

### **3.1.6 Харилцагчийн онлайн үйлчилгээ**

2018 онд харилцагчдын төлбөр тооцооны дансыг баталгаажуулах, ҮЦК-уудаас файл болон цаасан хэлбэрээр хүлээн авдаг шимтгэлийн тооцооллыг хялбарчлах, харилцагч, ҮЦК, АТТ ХХК-ийн хоорондын гурвалсан гэрээ байгуулснаар мөнгө хүсэх өргөдлийг онлайнар хүлээн авах боломж бүхий онлайн үйлчилгээний веб системийг ЕСМ ХХК-тай гэрээ байгуулсны үндсэн дээр захиалга өгч хөгжүүлэн, туршиж хүлээн авсан хэдий ч эрх зүйн орчин болон DvP ажлын хэсгийн тайлан төлөвлөгөөнөөс хамаарч нэвтрүүлэхээ түр хүлээж байгаа болно.

## 4. САНХҮҮГИЙН БОЛОН БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА

### *Санхуу, нягтлан бодох бүртгэл*

2019 оны хагас жилийн байдлаар нийт 623,568.8 мян төгрөгийн орлоготой ажиллав.

Ерөнхий ба удирдлагын зардал 249,493.6 мян төгрөг, бусад зардал 3,783.7 мян төгрөг, нийт үйл ажиллагааны зардал 253,277.4 мян төгрөг болсон байна. Татвар төлөхийн өмнөх ашиг 370,291.5 мян төгрөг гарснаас орлогын албан татварын зардал 36,855.9 мян төгрөгийг хасаад тайлант үеийн цэвэр ашиг 333,435.6 мян төгрөг гарсан байна.

Тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагаа буюу тооцооны шимтгэлийн орлого 396,482.6 мян төгрөг болсноор 2019 оны төлөвлөсөн орлогын 59%-ийг биелүүлээд байна. Нийт зардал 253,277.4 мян төгрөг гарсан нь 2019 оны төлөвлөгөөт зардлын 45%-ийг эзэлж байна. 2018 оны мөн үетэй харьцуулахад тооцооны шимтгэлийн орлого 56%-иар, хүүний орлого 20%-иар, үйл ажиллагааны зардал 33%-иар, цэвэр ашиг 47%-иар тус тус өссөн үзүүлэлттэй гарлаа.

Балансын нийт хөрөнгө 2018 онтой харьцуулахад 57%-иар буурсан нь Арилжаанд оролцогчдод өгөх өглөг 92%-иар багасч тэр хэмжээгээр арилжаанд оролцогчдын банкинд байршуулсан мөнгөн хөрөнгө буурсан нь нөлөөлсөн байна.

Эхний хагас жилд Компанийн 2019 оны төсөв албан ёсоор эцэслэн батлагдаж амжаагүй учраас үндсэн хөрөнгийн худалдан авалт хийгээгүй бөгөөд харин зайлшгүй ажлын шаардлагаар төсвийн төслийг ТУЗ-аар хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл, тогтоолыг үндэслэн 2,0 сая төгрөгийн үнийн дүн бүхий компьютер, 352.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий цаг бүртгэлийн төхөөрөмжийг шууд худалдан авалтаар хийсэн болно.

Тайлант хугацаанд нийт 2,795.5 мян төгрөгийн бараа материалын худалдан авалт хийгдэж, бараа материалын хагас жилийн тооллогыг 06-р сард зохион байгуулсан бөгөөд тооллогоор зөрчил, дутагдал илрээгүй.

# “АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО ҮЦК” ХХК

## АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО ҮЦК ХХК САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(2019 оны 2 дугаар улирлын байдлаар)

ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 06 сарын 30	2019 оны 06 сарын 30	%
<b>ХӨРӨНГӨ</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгөн хөрөнгө	13,802,772,173.14	5,821,700,326.32	-58%
Дансны авлага	44,424,329.65	57,428,539.73	29%
Бусад авлага	595,630.63		-100%
Бусад санхүүгийн хөрөнгө			
Бараа материал	7,906,642.78	441,600.00	-94%
Урьдчилж төлсөн тооцоо			
<b>Нийт эргэлтийн хөрөнгө</b>	<b>13,855,698,776.20</b>	<b>5,879,570,466.05</b>	<b>-58%</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	36,950,475.02	49,224,616.34	33%
Биет бус хөрөнгө	993,853.20	9,793,853.20	885%
Хойшлогдсон татварын хөрөнгө	1,421,071.75	2,466,516.02	74%
Бусад эргэлтийн бус хөрөнгө	2,636,991.67		-100%
<b>Нийт эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>42,002,391.64</b>	<b>61,484,985.56</b>	<b>46%</b>
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>13,897,701,167.84</b>	<b>5,941,055,451.61</b>	<b>-57%</b>
<b>СР ТӨЛБӨР БА ӨМЧ</b>			
<b>Богино хугацаат өр төлбөр</b>			
Арилжаанд оролцогчдын өглөг	9,578,216,089.64	750,799,813.66	-92%
Цалингийн өглөг	17,583.18		-100%
Татварын өглөг	17,872,045.01	21,724,896.22	22%
НДШ-ийн өглөг			
Бусад богино хугацаат өр төлбөр	1,097,410.36		-100%
<b>Нийт богино хугацаат өр төлбөр</b>	<b>9,597,203,128.19</b>	<b>772,524,709.88</b>	<b>-92%</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>			
Хойшлогдсон татварын өр	1,421,071.75	2,466,516.02	74%
<b>Нийт урт хугацаат өр төлбөр</b>	<b>1,421,071.75</b>	<b>2,466,516.02</b>	<b>74%</b>
<b>Нийт өр төлбөр</b>	<b>9,598,624,199.94</b>	<b>774,991,225.90</b>	<b>-92%</b>
<b>Эздийн өмч</b>			
Өмч			
Төрийн	950,893,520.75	4,000,000,020.75	321%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		9,560,000.00	
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	3,049,106,500.00		-100%
Хуримтлагдсан үр дүн	299,076,947.15	1,156,504,204.96	287%
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>4,299,076,967.90</b>	<b>5,166,064,225.71</b>	<b>20%</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН</b>	<b>13,897,701,167.84</b>	<b>5,941,055,451.61</b>	<b>-57%</b>

# “АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО ҮЦК” ХХК

## АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО ҮЦК ХХК САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

(2019 оны 2 дугаар улирлын байдлаар)

ҮЗҮҮЛЭЛТ	2018 оны 06 сарын 30	2019 оны 06 сарын 30	%
<b>БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО</b>			
Арилжааны шимтгэлийн орлого	253,954,539.29	396,482,636.44	156%
Бусад орлого			
<b>Үйл ажиллагааны орлогын дүн</b>	<b>253,954,539.29</b>	<b>396,482,636.44</b>	<b>156%</b>
<b>Үйл ажиллагааны зардал</b>			
Ерөнхий ба удирдлагын зардал	185,901,688.40	249,493,644.26	134%
Бусад зардал	4,928,260.00	3,783,740.00	77%
<b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>190,829,948.40</b>	<b>253,277,384.26</b>	<b>133%</b>
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>63,124,590.89</b>	<b>143,205,252.18</b>	<b>227%</b>
<b>Үйл ажиллагааны бус орлого</b>			
Хүүний орлого	189,774,733.53	227,086,249.21	120%
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>	<b>252,899,324.42</b>	<b>370,291,501.39</b>	<b>146%</b>
Орлогын татварын зардал	26,267,707.18	36,855,889.51	140%
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>226,631,617.24</b>	<b>333,435,611.88</b>	<b>147%</b>

## АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО ҮЦК ХХК ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(2019 оны 2 дугаар улирлын байдлаар)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ҮР ДҮН	(Төгрөгөөр)
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>4,000,000,020.75</b>	<b>9,560,000.00</b>	<b>858,630,159.78</b>	<b>4,868,190,180.53</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(35,561,566.70)	(35,561,566.70)
Өмчид гарсан өөрчлөлт			-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Тайланг үеийн үр дүн	-	-	333,435,611.88	<b>333,435,611.88</b>
<b>2019 оны 03-р сарын 31-рх үлдэгдэл</b>	<b>4,000,000,020.75</b>	<b>9,560,000.00</b>	<b>1,156,504,204.96</b>	<b>5,166,064,225.71</b>

### *Хууль эрх зүй, журам заавар*

Хууль тогтоомжийн төсөлд саналаа өгөх, журам дүрэм боловсруулах, тушаал, албан тоот боловсруулах, албан тоотод хариу өгөх, гэрээ хэлцлийн төсөл боловсруулах, холбогдох ажилтнуудад хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх зэрэг ажлууд хийгдлээ.

Компанийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн, эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор 2019 оны эхний хагас жилд дараах журмууд дээр ажиллаж үндсэн үйл ажиллагааны журмаас бусдыг нь шинэчлэн баталлаа. Үүнд:

- Компанийн нууцын тухай журам;
- Хөдөлмөрийн дотоод журам;
- Ажилтны ёс зүйн дүрэм;
- Захирлын зөвлөлийн ажиллах журам;
- Үнэт цаасны арилжааны төлбөр, мөнгөн гүйлгээний журам;

Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон бусад байгууллагуудаас тус компанийн нэр дээр тогтмол ирдэг хуулийн төсөл, журам заавар, ажлын хэсгийн дүгнэлт зэрэг баримт бичгүүдэд тухай бүрт нь санал боловсруулж ирсэн билээ.

Компанийн 2019 оны эхний хагас жилд нийт 85 аж ахуйн нэгж, иргэнтэй гэрээ байгуулсан бөгөөд үүнд: хугацаатай хадгаламжийн гэрээ 5, цахим үйлчилгээний гэрээ 1, түрээсийн гэрээ 1, худалдах худалдан авах гэрээ 5, ажил гүйцэтгэх гэрээ 5, Тусгай нөхцөлт харилцах дансны гэрээ 1, хамтран ажиллах гэрээ 1, Үнэт цаасны арилжааны мөнгөн төлбөр, тооцоог гүйцэтгэх түр гэрээ 45, Мэдээлэл дамжуулах гэрээ 19, төлбөр тооцооны номинал дансны гэрээ 2-ыг тус тус байгуулсан байна. Гэрээгээр хүлээсэн үүргээ талууд бүрэн биелүүлэн ажиллаж байна.

Сангийн яамнаас зохион байгуулсан ЭБАТ-уудад зориулсан сургалтанд 2019.01.03-ны өдөр эрх бүхий албан тушаалтанаа хамруулсан. Сангийн яамны 2018.12.28-ны өдрийн 11/8093 тоот албан бичгийн дагуу 2018 оны ХАСХОМ гаргах албан тушаалтны нэрсийг гарган 2019.01.03-ны өдрийн 01/01 тоот албан бичгээр хүргүүлсэн. ХАСХОМ бүртгэхтэй холбоотой цахим бүртгэлээс 2 ажилтныг хасч Сангийн яамны ЭБАТ-д мэдээлсэн.

Компанийн ХОМ гаргах эрх бүхий албан тушаалтнууд хуулийн хугацаанд бүгд ХАСХОМ гарган дууссан бөгөөд тайланг нэгтгэн мэдээг 2019.02.21-ны өдрийн 01/49 тоот албан бичгээр болон имэйлээр хүргүүлсэн. Тайлант хугацаанд 4 хүн ХАСХОМ гаргахаар нэмж бүртгэгдсэн.

2019 онд компанийн нууцыг хамгаалахтай холбоотой хийгдэх ажлын төлөвлөгөөг батлан, төлөвлөгөөний дагуу холбогдох ажлуудыг хийсэн. Үүнд: Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн зөвшөөрлийг үндэслэн Гүйцэтгэх захирлын 2019 оны Б/29-р тушаалаар компанийн Нууц хамгаалах ажилтныг томилж, тус газраас зохион байгуулдаг нууц хамгаалах ажилтнуудыг бэлтгэх сургалтанд хамруулсан. Мөн Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн саналыг үндэслэн Гүйцэтгэх захирлын А/36-р

## “АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО ҮЦК” ХХК

---

тушаалын 1-р хавсралтаар “Компанийн нууцыг хамгаалах журам”, 2-р хавсралтаар компанийн нууц мэдээллийн жагсаалтыг тус тус баталсан.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу компанийн нийт компьютер, серверт хувийн хэрэг нээж, баталгаажуулах, компанийн хэмжээнд ашиглагдаж буй тэмдэг, дардасны бүртгэлийг хөтөлж, баталгаажуулах ажлууд хийгдээд байна.

### *Гадаад харилцаа, сургалт*

ACG байгууллагын гишүүний хувьд тус байгууллагатай байнгын холбоотой ажиллаж судалгаанд оролцох, мэдээлэл хүргүүлэх, туршлага судлах зорилгоор сургалтад хамрагдах зэрэг асуудлаар санал солилцлоо.

Ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, шинэ техник технологи судлах зорилгоор дараах сургалтад ажилтнуудаа хамруулав. Үүнд:

- Худалдан авах ажиллагааны сургалт;
- Компанийн засаглалын сургалт;
- Татварын болон хөрөнгийн тооллого, дахин үнэлгээний сургалт;
- АТГ-аас зохион байгуулсан сургалт;
- “Check Point Software Technologies LTD” –ийн мэдээллийн аюулгүй байдлын цогц шийдэл болсон Next Generation Firewall дээр мониторинг хийх сургалт,
- “Check Point” удирдлагын системийн сургалт,
- “QNAP Solution day” их хэмжээний өгөгдлийг хадгалах, удирдах сургалт.

2019 оны 5-р сарын 03-ны өдөр ТӨБЗГ-аас зохион байгуулсан "Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага-2018" өдөрлөг, 2019 оны 1-р сарын 20-ноос 28-ны өдрийн хооронд Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооноос зохион байгуулсан 5 төрлийн спортын арга хэмжээнд нийт ажилтнуудыг хамруулан, амжилттай оролцлоо.

### *Бусад ажил*

Санхүүгийн зохицуулах хорооны ээлжит шалгалтад хамрагдаж тайланг хүлээн авсан бөгөөд тус тайлангаар өгөгдсөн албан шаардлага, үүрэг даалгаварт тайлбар өгөх, гүйцэтгэлийг хангуулах ажлуудыг зохион байгуулж байна. Уг шалгалтын үеэр Санхүүгийн байгууллагуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны эрсдлийн судалгаа хийгдсэний дагуу эрсдлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж байна.

2019 оны эхний хагас жилд компанид нийт 350 албан бичиг ирснийг бүртгэн компаниас нийт 120 албан бичиг явуулсан байна. ТТЭУА-ны Мөнгөн хөрөнгө болон харилцах банкны үлдэгдлийн мэдээг өдөр бүрээр нь сканнердан файл үүсгэн хадгалав.

## 5. ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт хэрэгжүүлэх замаар хөрөнгийн зарцуулалтыг сайжруулах, хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн хараат бус бодитой дүгнэлт гарган эрсдлийг бууруулах, хяналтын үр нөлөөтэй тогтолцоог бий болгох хяналт шалгалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд ажиллалаа.

Санхүү, нягтлан бодох бүртгэлд хийсэн дотоод хяналт шалгалтыг дараахь чиглэлүүдээр хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн бүртгэлд хийх дотоод хяналт шалгалт хийх
- Бараа материал, үндсэн хөрөнгийн бүртгэлд дотоод хяналт шалгалт хийх
- Өглөгийн бүртгэлд хийх дотоод дотоод хяналт шалгалт хийх
- Авлагын бүртгэлд хийх дотоод дотоод хяналт шалгалт хийх
- Хувьцаа, бонд, компанийн бондын тооцооны шимтгэл болон нэмэлт үйлчилгээнд хийх дотоод хяналт шалгалт хийх

Нийгмийн даатгалын шимтгэл, татварын тооцоололд дотоод хяналт шалгалтыг дараахь чиглэлүүдээр хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- НДШ-ийн болон Албан татварын тайланд хийх дотоод хяналт шалгалт
- Цалин, татвар, ашиглалт болон зардалд хийх дотоод хяналт шалгалт

Санхүүгийн тайланд хийсэн дотоод хяналт шалгалтыг дараахь чиглэлүүдээр хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Орлого: Үндсэн үйл ажиллагааны орлого, үндсэн бус үйл ажиллагаа
- Зардал: Борлуулсан бүтээгдэхүүний өртөг, удирдлага
- Санхүүгийн тайлангийн гүйцэтгэлийг харьцааны шинжилгээгээр тодорхойлон үнэлэлт өгөх
- Капиталын хөрөнгө оруулалт, өнөөгийн хөрөнгө, зээл ба урьдчилгаа, ашиг хувиарлах бодлого зэрэг нөөцийн ашиглалтын үр өгөөжийг оновчтойгоор тодорхойлох

Санхүүгийн тайланд хийсэн дотоод хяналт шалгалтыг дараахь чиглэлүүдээр хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцах тухай хуулийн хэрэгжилтийн тайлан мэдээ гаргах
- Компанид мөрдөгдөж буй дүрэм журмын хэрэгжилтын байдалд нийцлийн аудит хийх
- Харилцагчдаас ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэх болон бусад

# “АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО ҮЦК” ХХК

төлөвлөгөөт бус асуудлаар дотоод хяналт шалгалт хийж

Дотоод хяналт шалгалтын ажлын үр дүн:

1. Бараа материалд хийсэн шалгалтын тухайд:

Шалгалтад хамрагдсан няравын бараа материал болон мөнгөн хөрөнгийн тайлан болон анхан шатны бүртгэл (тайлан)-д анхан шатны дагалдах баримт материалыг бүрэн бүрдүүлсэн байна. SOLARSYS программ болон Бараа материалын няравын үлдэгдэлийн харьцуулалт, баталгаажуулалтын явцад алдаа гараагүй болно.

2. Цалин, НДШ болон ХХОАТатварын тайланд хийсэн шалгалтын хувьд:

2018 болон 2019 оны эхний хагас жилийн тайлан, НББүртгэлийн баримт материалыг компанид хэрэглэгдэж байгаа НББүртгэлийн зарчмууд, зардлын тооцоолол зэрэг санхүүгийн тайлан баримтуудтай тулган шалгахад татварын болон хууль, эрхийн актын дагуу зохих журмын хүрээнд бүрэн хийгдсэн байна.

3. Шатахуун болон гараашийн түрээсийн тооцоог хэсэгчлэн шалгасан тухай:

- Жолоочийн шатахуун зарцуулалтын тооцоо болон жолоочийн замын хуудсаар хийгдэж буй зарцуулалтанд хэсэгчилсэн шалгалт хийж замыг хуудсаар хэрхэн хяналт тавих тооцоог хэрхэн хийдэг тухай арга зүйн зөвлөмж өгөхийн хамт жолоочийн өдөр тутмын маршрутыг хэрхэн зохиох, хяналт тавих тухай процессийн диаграмм гаргасан.
- Автомашины гараашийн түрээсийн төлбөр төлөлт, орлогын татварын суутгал зэрэгт хяналт, тооцоог хийж үлдэгдлийг тайлан тэнцэлтэй тулган баталгаажуулсан.

## 6. ДҮГНЭЛТ

Компани 2019 оны эхний хагас жилийн төлөвлөгдсөн ажлуудаас ТУЗ-ийн хараат бус гишүүд томилуулах, эрсдэлийн журмын төсөл эцэслэн боловсруулах, архивын материалуудыг зориулалтын байр саванд шилжүүлэх ажлуудаас бусад ажлууд биелсэн байна. Компанийн 2019-2021 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөө, 2019 оны бизнес төлөвлөгөөг боловсрууллаа. Компанийн дотоод журам болон бусад 4 журмыг шинэчлэн баталж, үндсэн үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулж байна. Үндсэн үйл ажиллагаа холбогдох журмын дагуу явагдаж, төлбөр тооцоо үнийн дүнгээр төлөвлөсөн хэмжээнээс давж хийгдлээ.

Үндсэн үйл ажиллагааны орлого 396.5 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 227.1 сая төгрөг, нийт 623.6 сая төгрөгийн орлоготой ажилласнаар Бизнес төлөвлөгөөнд тусгагдсан орлого 61.1 хувийн биелэлттэй байна. Нийт зардал 253.3 сая төгрөг гарсан нь 2019 оны төлөвлөгөөт зардлын 45%-ийг эзэлж байгаа бол цэвэр ашиг 333.4 сая төгрөгт хүрсэн нь 2018 оны мөн үетэй харьцуулахад 1,5 дахин өссөн үзүүлэлттэй гарсан байна.



## “АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО ҮЦК” ХХК

---

Бизнес төлөвлөгөө албан ёсоор батлагдаагүйгээс шалтгаалан Компанийн 2019 оны худалдан авах ажиллагаанууд сүүлийн хагаст хийгдэхээр хойшилж байна.

EBRD-ийн төслийн хүрээнд төлбөр тооцооны үйл ажиллагаанд хийгдэх өөрчлөлтийн ажлын тайланд үндэслэн Сангийн сайдын тушаалаар T+2/DvP систем нэвтрүүлэх ажлын хэсгийг шинэчлэн байгуулж ажлын хэсэгт Компанийн удирдлагууд багтаад байна. Энэхүү тушаал, ажлын төлөвлөгөөний дагуу 2019 оны сүүлийн хагаст тооцооны үйл ажиллагааг шинэчлэх, дүрэм журмуудыг батлах, батламжлуулах, тооцооны гишүүн элсүүлэх, АСН+ систем нэвтрүүлэх, үндсэн системийн бодлогын даалгавар боловсруулах зэрэг ач холбогдол бүхий ажлууд сүүлийн хагас жилийн гол зорилт болон хүлээгдэж байна.